

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 2 сарын 18-ны өдөр

№ 05

Улаанбаатар хот

### *Ногдол ашиг хуваарилах тухай*

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалт, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 28 дугаар “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” тогтоол, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.8 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.8.6 дахь заалт, Ногдол ашгийн бодлогын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Сэндли ББСБ” ХК-ийн 2024 оны татварын дараах цэвэр ашгаас 20,01 хувийг буюу 1,701,367,700.00 /нэг тэрбум долоон зуун нэг сая зуун гурван жаран долоон мянга долоон зуу/ төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
2. Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээг 7.61 /долоон төгрөг жаран нэгэн мөнгө/ төгрөгөөр тогтоосугай.
3. Ногдол ашиг авах эрхтэй Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдрөөр тогтоосугай.
4. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашгаас татварыг суутган тооцож, “Үнэт цаасны төлбөр тооцооны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар 2024 оны 4 дүгээр сарын 10-ний өдөр олгосугай.
5. Ногдол ашиг хуваарилж, олгох тухай шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, ногдол ашгийг холбогдох хууль тогтоомж, энэхүү тогтоолд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд олгох ажлыг зохион байгуулах, ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГА Б.НАРАНБАТ

  
